

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2022 НААДМЫН 1 ДҮГЭЭР ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ АЖЛЫН ТАЙЛАН



2022 он

1 ДҮГЭЭР ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 1.2-т “Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээлч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно”, 1.5-д “Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож монгол соёлыг түгээн дэлгэрүүлж Монгол Улсын нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.2.3-т “Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадам брэнд бий болгох”, 2.6.2.6-д “Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чиглэлээр олон улсын арга хэмжээг зохион байгуулна”, 2.6.3.4-т “Нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлж бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадвар бүхий монгол брэндийг бий болгож соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ”, 3.4.5.1-т “Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, цар хүрээг өргөжүүлнэ гэж тус тус заасан.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьчас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан түгээх дэлгэрүүлэх зорилгоор гурван жил тутам улсын хэмжээнд соёлын биет бус өвийн их наадмыг зохион байгуулна гэж тусгасан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас ирүүлсэн 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/188 дугаар Соёлын биет бус өвийн их наадам зохион байгуулах тухай албан бичиг, удирдамжийг үндэслэн Дархан-Уул аймгийн соёлын биет бус өвийн “Нүүдэлчин Монгол” наадмын I дүгээр шатны шалгаруулалтыг 2022 оны 7 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа.


“Нүүдэлчин Монгол” наадмыг орон нутагт зохион байгуулах Удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулж аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлангаар батлуулан Соёл, урлагийн байгууллагууд, сумдын ЗДТГазар, Соёлын төвүүдэд албажуулж хүргүүлэв.

Тус наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд хуралдуулж удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг танилцууллаа.

Ажлын хэсгийн хуралд аймгийн Соёл, урлагийн газрын Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Соёл-Эрдэнэ, Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа болон Соёл, урлагийн газрын мэргэжилтнүүд, Залуучууд театр, аймгийн Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Зураач урчуудын холбоо, Сумдын соёлын төв, зарим хэлтэс агентлагийн удирдлагууд танхимын болон цахим хэлбэрээр оролцлоо.



"НҮҮДЭЛЧИН МОНГОЛ"
наадмын талбайн байршил



Дархан-Уул аймгийн соёлын биет бус өвийн "Нүүдэлчин Монгол" наадмыг Дархан сумын 3 дугаар багт байрлах баяр наадмын талбайд /олны хэлж заншснаар хуучин стадион/ дээрх зураглалын дагуу зохион байгуулав.

Дархан-Уул аймагт ажиллаж амьдарч буй Халх, Казак, Хотон, Урианхай, Захчин, Өөлд, Мянгад, Торгууд, Буриад зэрэг үндэстэн угсаатны судалгааг гаргаж оролцоо хангах тал дээр нутгийн зөвлөлүүдэд Удирдамж хүргүүлэн хамтран ажилласан.
1 дүгээр шатны шалгаруулалтыг зохион байгуулсан ажлын тайлан

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Б.ЖАВХТАН
2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН "НҮҮДЭЛЧИН МОНГОЛ" СОЁЛЫН БИЕТ БУС
ӨВИЙН НААДМЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Соёлын өвийг хамгаалах тухай хууль, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өв /СББӨ/-ийг хамгаалах тухай 2003 оны Конвенцийн дагуу Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, дэмжин хөгжүүлэх, судалж сурталчилах, долоон ай савын хүрээнд Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг тодруулж алдаршуулах, орон нутгийн соёлын өвийн бүртгэл-мэдээллийн нэгдсэн санг баяжуулахад оршино.

Хоёр. Зорилт:

2.1. Үндэсний СББӨ, түүнийг өвлөн уламжлагчдын үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн авьяас билиг, арга барил, дэг сургуулийг өвлөн уламжлуулах, хамгаалах, сурталчлах;

2.2. Соёлын биет бус өв, түүний дотор ЮНЕСКО-гийн СББӨ-ийн Төлөөллийн Жагсаалт, яаралтай хамгаалах шаардлагатай өвийн Жагсаалтад Монгол Улсаас бүртгэгдсэн өвүүд болон бусад өвийн төрөл зүйлийг хадгалж хамгаалж буй үйл ажиллагаанд дүгнэлт хийж, СББӨ-ийг хадгалж хамгаалах дунд, урт хугацааны бодлогыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, өв соёлын судалгаа, сурталчилгаа, сургалтыг эрчимжүүлэх;

2.3. Соёлын биет бус өвийг 7 ай савын хүрээнд, Эх хэл болон аман уламжлал, илэрхийллүүд; гар урлал; байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, арга ухааныг хөгжүүлж, сэргээж, таниулан сурталчлах, өвлөн уламжлуулах;

Гурав. Зохион байгуулах хугацаа, газар:

2022 оны 07 дугаар сарын 10-ны өдөр, 11:30-18:00 цагт Дархан сумын 3 дугаар багт байрлах Баяр наадмын талбайд зохион байгуулна.

Дөрөв. Наадмын зохион байгуулалт:

4.1. Сум тус бүр сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан зохион байгуулалттай, бэлтгэл ажил ханган оролцоно.

4.2. Наадамд оролцогчдын Дархан хотод ирэх, буцах унааны шатахууны зардлын тодорхой хэсгийг зохион байгуулагч тал хариуцна.

4.3. Сум тус бүр оролцогчдын унааны бүрэн бүтэн байдал, хүмүүсийн аюулгүй байдлыг бүрэн хангаж оролцоно.

4.4. Наадамд оролцсон шилдгүүдийг Нүүдэлчин Монгол үндэсний их наадамд оролцуулна.

4.5. Иргэдийн гар дээр байгаа бүтээлүүдийг үзэсгэлэнд дэлгэн үзүүлэх, хяналт тавих ажлыг оролцогч тал бүрэн хариуцна.

Тав. Шалгаруулах ангилал, төрөл зүйл:

Анхан шатны шалгаруулалтыг мэргэжлийн шүүгчид явуулж Соёлын биет бус өвийн дараах долоон ай савын хүрээнд ангилал, төрөл зүйл тус бүрээр 1 байр шалгаруулж, урамшуулна.

1. Эх хэл аман уламжлал
2. Ардын язгуур урлаг
3. Уламжлалт гар урлал
4. Уламжлалт зан үйл, ёслол баяр наадам
5. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи
6. Мал маллах арга ухаан
7. Уламжлалт арга ухаан

Зургаа. Шагналын сан:

Нийт 3.000.000 төгрөг байна.


ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Дархан сумын Засаг даргын
Тамгын газар

Аймгийн Соёл, урлагийн газар

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Аймгийн Музей, Залуучууд театр,
Төв номын сан, Хүүхдийн номын ордон,
Сумдын Засаг даргын Тамгын газар,
Соёлын төв, Ахмадын хороо



 ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ОРЛОГЧ Б.ЖАВХЛАН
 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН "НҮҮДЭЛЧИН МОНГОЛ" СОЁЛЫН БИЕТ БУС
ӨВИЙН НААДМЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Дархан сумын баяр наадмын талбайд
зохион байгуулна.

№	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа /сар, өдөр/	Хариуцах байгууллага	Хяналт тавих байгууллага
1	СББӨ-ийн наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, батлуулах	2022.06.29	Соёл, урлагийн газар	
2	СББӨ-ийн наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө, удирдамж, тусгай хөтөлбөр боловсруулж, батлуулах	2022.06.29	Соёл, урлагийн газар	
3	СББӨ-ийн наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн хурлыг хийж, удирдамж танилцуулах, үүрэг чиглэл өгөх	2022.06.30	Соёл, урлагийн газар	
4	СББӨ-ийн наадмын удирдамж, хөтөлбөрийг сумдад албан бичгээр хүргүүлэх	2022.07.01	Соёл, урлагийн газар	
5	СББӨ-ийн наадамтай холбоотой төсвийн төсөл боловсруулж, батлуулах	2022.07.01	Соёл, урлагийн газар	
6	Сум тус бүр удирдамжид заасны дагуу бэлтгэл ажил хангаж, зохион байгуулалттай оролцох	2022.07.01-10	Сумдын Соёлын төв	Соёл, урлагийн газар
7	СББӨ-ийн "Нүүдэлчин Монгол" наадмын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд давтамжтай мэдээлж сурталчлах	2022.07.03-10	Соёл, урлагийн байгууллагууд	Соёл, урлагийн газар
8	СББӨ-ийн наадмын батламжийн эх бэлтгэж хэвлүүлэх, шагнал бэлтгэх	2022.07.03-08	Дархан сумын ЗДТГ	Соёл, урлагийн газар
9	СББӨ-ийн наадмын болон Соёл, урлагийн газрын нэр бүхий хулдаасан хэвлэлийн эх бэлтгэж, хэвлүүлэх	2022.07.04-09	Соёл, урлагийн газар	



10	Тавгийн идээ, айраг, ус ундаа, чихэр зэрэг ахуйн бусад зүйлийг худалдан авах	2022.07.08-09	Соёл, урлагийн газар	
11	СББӨ-ийн наадмын дугуй тайз, хөгжим, өсгөгч, микрофон байрлуулах, бэлэн байдлыг хангах	2022.07.09-10	Дархан сумын ЗДТГ	
12	СББӨ-ийн наадмын талбайд гэр барих	2022.07.09 18:00-20:00	Соёл, урлагийн байгууллагууд	Соёл, урлагийн газар
13	Гэрт үзмэр, уран зураг, монгол бичиг зэрэг соёлын бүтээгдэхүүнээр тохижуулж дэглэх	2022.07.10 20:00-21:00	Аймгийн Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон	Соёл, урлагийн газар
14	Гэрт тавих сандал бэлдэх	2022.07.10	Хүүхдийн номын ордон	Соёл, урлагийн газар
15	Гэрт тавих ширээ	2022.07.10	Соёл, урлагийн газар	
16	Гэрт тавих мөнгөн аяга, шанага, айргийн хул, цар, данх, домбо зэрэг бусад зүйлс /Монгол ахуй/	2022.07.10	Төв номын сан, Аймгийн Музей	Соёл, урлагийн газар
17	Гэр бусад эд зүйл ачих автомашин бэлдэх /портер/	2022.07.10	Соёл, урлагийн газар	
18	Дархан сумын Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг оролцуулах	2022.07.10	Аймгийн Музей	Соёл, урлагийн газар
19	Орхон сумын Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг оролцуулах	2022.07.10 10:00	Орхон сум Соёлын төв	Аймгийн Музей
20	Хонгор сумын Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг оролцуулах	2022.07.10 10:00	Хонгор сум Соёлын төв	Аймгийн Музей
21	Шарын гол сумын Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг оролцуулах	2022.07.10 10:00	Шарын гол сум Соёлын төв	Аймгийн Музей
22	Асар барих /Сум тус бүр/	2022.07.09	Орхон, Хонгор, Шарын гол сум	Дархан сумын ЗДТГ
23	Олон ястнуудыг цуглуулах	2022.07.10	Статистик, ХХҮГ, БТСГ, Залуучуудын холбоо, Стандарт хэмжил зүйн газар, ЖСИ, БШУГ, ГБХЗХГ	Дархан сумын ЗДТГ
24	Олон ястны цугларалтад ирсэн иргэдэд "Нүүдэлчин Монгол"	2022.07.10	Аймгийн Музей	Соёл, урлагийн газар

	наадмын мэдээлэл өгч, оролцуулах			
25	Олон ястнуудын гэрийг өөр өөрийн онцлогийг шингээн тохижуулах	2022.07.09	Статистик, ХХҮГ, БТСГ, Залуучуудын холбоо, Стандарт хэмжил зүйн газар, ЖС, БШУГ, ГБХЗХГ	Дархан сумын ЗДТГ
26	Аймгийн СББӨ бүртгэлд бүртгэлтэй ахмадуудыг "Нүүдэлчин Монгол" наадамд оролцуулах	2022.07.10	Музей, Ахмадын холбоо	Соёл, урлагийн газар
27	СББӨ-ийн Нүүдэлчин Монгол наадамд оролцох иргэдийн бүртгэл хийх	2022.07.10	Музей, Төв номын сан	Соёл, урлагийн газар
28	Шүүгч урьдчилан бэлдэх	2022.07.10	Залуучууд театр, Аймгийн Музей	Соёл, урлагийн газар
29	Хөтлөгч, урлагийн номер урьдчилан бэлдэх	2022.07.10	Залуучууд театр	Соёл, урлагийн газар
30	Соёл, урлагийн газрын гэрт үйлчлэх ажилтнуудын хуваарь	2022.07.10 10:00-14:00 ХНО 14:00-18:00 Төв номын сан	Төв номын сан, Хүүхдийн номын ордон	Соёл, урлагийн газар
31	СББӨ-ийн наадмын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах	2022.07.10-11	Дархан сумын ЗДТГ-ын ХМА	Соёл, урлагийн газар
32	СББӨ-ийн наадамд оролцсон өвлөн уламжлагчдын зураг, бичлэг хийж баримтжуулах	2022.07.10	Аймгийн Музей Залуучууд театр	Соёл, урлагийн газар
33	Гэр хураах	2022.07.10 19:00	Соёл, урлагийн байгууллагууд	Соёл, урлагийн газар
34	СББӨ-ийн наадмын эргэн тойронд үүссэн хог хаягдлыг тухай бүр цэвэрлэх, хогийн сав байршуулах	2022.07.10	Дархан сумын ЗДТГ Соёл, урлагийн байгууллагууд	Соёл, урлагийн газар
35	СББӨ-ийн наадмын тайланг бичиж Соёлын яаманд хүргүүлэх	2022.08.01	Соёл, урлагийн газар	

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд сурталчлах чиглэлээр:

Дархан-Уул аймгийн соёлын биет бус өвийн "Нүүдэлчин Монгол" наадмын тухай болон хэрхэн зохион байгуулах талаар хэвлэлийн бага хурал хийж аймгийн Засаг даргын тамгын газрын Мэдээлэл технологийн албаны darkhan.gov.mn цахим хуудас, орон нутгийн DBS, RGB телевизийн суваг, Цэц.мн цахим хуудас, Дархан сумын Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллээр албаны цахим хуудсаар тус тус дамжуулан иргэд, олон нийтэд сурталчиллаа.




Мөн Дархан-Уул аймгийн соёлын биет бус өвийн "Нүүдэлчин монгол" наадам зохион байгуулах тухай зурагт мэдээллийг аймаг, сумын баяр наадмын хөтөлбөрт албан ёсоор оруулж, иргэдэд мэдээлэв.



**"НҮҮДЭЛЧИН МОНГОЛ"
СОЁЛЫН БИЕТ БУС
ӨВИЙГ ӨВЛӨН
УЛАМЖЛАГЧДЫН
НААДАМ**

ЦЭВЭР ДАРХАН - ЦЭМЦГЭР НААДАМ
ДАРХАН
ДАРХАН ХОТ
БАРГУУНГЭДЭХ
60, 61 ЖИД
МОНГОЛ
ТУУХАНЫ БАГА
НААДАМ

ДАРХАН УУЛ АЙМГИЙН МҮЗЕЙ
БҮРТГЭЛ: 7037-3020
ТӨВ ЦЭНГЭЛДЭХ СТАДИОН 2022.07.10 12:00



**ЭХ ХЭЛ, АМАН
УЛАМЖЛАЛУУД**

ЦЭВЭР ДАРХАН - ЦЭМЦГЭР НААДАМ
ДАРХАН
ДАРХАН ХОТ
БАРГУУНГЭДЭХ
60, 61 ЖИД
МОНГОЛ
ТУУХАНЫ БАГА
НААДАМ

ТӨВ ЦЭНГЭЛДЭХ СТАДИОН
2022.07.10 12:00



**АРДЫН
ЯЗГУУР УРЛАГ**

ЦЭВЭР ДАРХАН - ЦЭМЦГЭР НААДАМ
ДАРХАН
ДАРХАН ХОТ
БАРГУУНГЭДЭХ
60, 61 ЖИД
МОНГОЛ
ТУУХАНЫ БАГА
НААДАМ

ТӨВ ЦЭНГЭЛДЭХ СТАДИОН
2022.07.10 12:00



**УЛАМЖЛАЛТ
АРГА УХААН**

ЦЭВЭР ДАРХАН - ЦЭМЦГЭР НААДАМ
ДАРХАН
ДАРХАН ХОТ
БАРГУУНГЭДЭХ
60, 61 ЖИД
МОНГОЛ
ТУУХАНЫ БАГА
НААДАМ

ТӨВ ЦЭНГЭЛДЭХ СТАДИОН
2022.07.10 12:00



Дархан-Уул аймагт нийт 75 соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч бүртгэлтэй байдаг бөгөөд "Нүүдэлчин Монгол" наадамд Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумаас нийт 110 оролцогч Эх хэл аман уламжлал, Монгол ардын язгуур урлаг, Уламжлалт гар урлал, Уламжлалт зан үйл, ёслол баяр наадам, Байгалийн сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга, Мал маллах арга ухаан зэрэг 7 ай савын хүрээнд ерөөл магтаал, хотон бий биелгээ, зан үйл, хайчилбар, хулсан хуур, баяд бий биелгээ, ардын бүжиг, ардын дуу, уртын дуу, бурханы хөрөг зураг, эсгий урлал, дарханы урлал, уран нугаралт, сийлбэр, гар урлал, ахуйн эдлэл хэрэглэл, оньсон тоглоом наадгай, ташлын

урлаг, олон үндэстэн ястны бий биелгээ, ардын урлагийн хөгжмийн төрлүүд, цагаан идээ боловсруулах, морь цоллох зэрэг төрөл зүйлээр оролцлоо.

Наадмын үйл ажиллагаа, оролцогчдын үзүүлбэрийг фото зураг, видео бичлэгээр баримтжуулсан.

Наадам 2022 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 12:00 цагт эхэлж, үдшийн 20:00 цагт өндөрлөсөн. Тус наадмын зохион байгуулалт, үйл явдлыг фото зургаар товч харуулав.



Зураг.1 "Нүүдэлчин Монгол" наадмыг Аймгийн Соёл, урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Соёл-Эрдэнэ нээж үг хэллээ.

Нээлтийн үйл ажиллагаанд Дархан сумын ИТХ-ын дарга Я.Бат-Очир, Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа, Дархан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батзул, Аймгийн Музейн дарга Д.Жамбалдорж, Төв номын сангийн дарга Б.Цэцэгсүрэн, Хүүхдийн Номын Ордны дарга Л.Мөнхбаатар, Залуучууд театрын дарга А.Болорсүх, Шүүгчдийн бүрэлдэхүүн болох Г.Нарангэрэл, Ш.Алтанцэцэг, Н.Хишигбаатар, Ц.Отгонбаяр, тус наадамд оролцсон үндэстэн, ястнуудыг хариуцаж ажилласан төрийн байгууллагуудын удирдлагууд оролцлоо.




Зураг.2 Нээлтийн үеэр Орхон сумын харьяат соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Г.Орших, Ш.Амгалан нар Ардын авьяастан цол тэмдгээр шагнууллаа.



Зураг.3 Дархан сумаас оролцож буй бие биелээчид



Зураг. 4 Хонгор сумын бүжигчид Казак ардын бүжиг Харага жороо



Зураг.5 Шарын гол сумын Гар урлалын бүтээлүүд



Зураг.6 Дархан сумын СББӨ-ийн өвлөн уламжлагчид



Зураг.7 Дархан сумын оролцогч Монгол ардын дуу



Зураг.8 С.Одонцоо шавь нарын хамт Бие биелгээ



Зураг.9 Орхон сумын ББӨ-ийн өвлөн уламжлагчид



Зураг.10 "Нүүдэлчин Монгол наадам" шүүгчдийн бүрэлдэхүүн

Наадмын ерөнхий шүүгчээр Урлаг судлаач, ахмад ажилтан Г.Нарангэрэл, Шүүгчээр Монгол Улсын гавьяат жүжигчин Г.Алтанцэцэг, Зураач урчуудын холбооны тэргүүн Н.Хишигбаатар, Соёл, урлагийн газрын урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Отгонбаяр нар ажиллалаа.



Зураг.11 "Нүүдэлчин Монгол" наадамд УИХ-ын гишүүн, АБГББХ-ны дарга Б.Баттөмөр хүрэлцэн ирж аймгийн Соёл урлагийн газрын гэрээр зочлон өвлөн уламжлагчдаа дэмжлээ.

Зураг.12-22 Тус наадамд аймгийн Соёл, урлагийн газар болон Сум тус бүр өөр өөрийн онцлогийг харуулсан олон үндэстэн, ястнуудын гэр барьж Дарханчууддаа соёлын биет бус өвийг танилцуулсан юм.





1 ДҮГЭЭР ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Дархан-Уул аймгийн соёлын биет бус өвийн "Нүүдэлчин Монгол" наадмын 1 дүгээр шалгаруулалт өргөн хүрээнд амжилттай зохион байгуулагдаж 2 дугаар шатны шалгаруулалтад оролцох 39 оролцогчийг шалгаруулж батламж, эрхийн бичиг, мөнгөн шагналыг тус тус олголоо.



Д/Д	Овог нэр	Төрөл	Шагнал
ДАРХАН СУМ			
1	Ц.Дүйнхэрсүрэн	Эх хэл аман уламжлал - Ерөөл магтаал	Батламж /100,000 төг/
2	Х.Журай	Ардын язгуур урлаг - Хотон бий биелгээ	Батламж /100, 000 төг/
3	Ч.Зунгарай	Уламжлалт зан үйл, ёслол баяр наадам - Зан үйл	Батламж /100,000 төг/
4	Б.Төмөрхуяг	Уламжлалт гар урлал - Хайчилбар	Батламж /100, 000 төг/
5	Д.Жавзанжав	Ардын язгуур урлаг - Хулсан хуур	Эрхийн бичиг /50,000 төг/
6	Б.Даариймаа	Ардын язгуур урлаг - Хотон бий биелгээ	Эрхийн бичиг /50,000 төг/
7	Б.Булган	Ардын язгуур урлаг - Хотон бий биелгээ	Эрхийн бичиг /50,000 төг/
8	Б.Цээлээ	Ардын язгуур урлаг - Хотон бий биелгээ	Эрхийн бичиг /50,000 төг/
9	Б.Таамж	Ардын язгуур урлаг - Хотон бий биелгээ	Эрхийн бичиг /50,000 төг/
10	С.Одонцоо	Ардын язгуур урлаг - Хотон бий биелгээ	Эрхийн бичиг /50,000 төг/
11	Б.Дэжидмаа	Ардын язгуур урлаг - Баяд бий биелгээ	Эрхийн бичиг /50,000 төг/
12	Ж.Нарантуяа	Ардын язгуур урлаг - Ардын бүжиг	Эрхийн бичиг /50,000 төг/
13	Ж.Цэвэлмаа	Ардын язгуур урлаг - Ардын дуу	Эрхийн бичиг /50,000 төг/
14	Ш.Наранцэцэг	Ардын язгуур урлаг - Ардын дуу	Эрхийн бичиг /50,000 төг/
15	Р.Содовдорж	Уртын дуу	Эрхийн бичиг /50,000 төг/
16	С.Мөнгөнзул	Уламжлалт гар урлал - Бурхан зураг	Эрхийн бичиг /50,000 төг/
17	Т.Жаргалсайхан	Уламжлалт гар урлал - Эсгий урлал	Эрхийн бичиг /50,000 төг/

18	Д.Түмэнжаргал	Уламжлалт гар урлал - Дарханы урлал	Эрхийн бичиг /50,000 төг/
19	Н.Мөнгөнбаяр	Уламжлалт гар урлал - Дарханы урлал	Эрхийн бичиг /50,000 төг/
20	Р.Оюунчимэг багштай "Угалз" хамтлаг /2 охин/	Уран нугаралт	Эрхийн бичиг /50,000 төг/
21	Г.Эрдэнэтөгс	Уламжлалт гар урлал - Сийлбэр	Эрхийн бичиг /50,000 төг/
22	Удвал	Гар урлал	Эрхийн бичиг /50,000 төг/
23	Жамсран	Ахуйн эдлэл, хэрэглэл	Эрхийн бичиг /50,000 төг/
24	Н.Абдукалик	Гар урлал	Эрхийн бичиг /50,000 төг/
25	Л.Алтангэрэл	Онъсон тоглоом, наадгай	Эрхийн бичиг /50,000 төг/
26	С.Отгонцэцэг	Ардын язгуур урлаг – Ардын дуу	Батламж /100,000 төг/
27	Батжаргал	Ардын язгуур урлаг – Ташлын урлаг	Эрхийн бичиг /50,000 төг/
28	Ч.Орлом, Д.Буяндэлгэр	Ардын язгуур урлаг – Бий биелгээ	Эрхийн бичиг /50,000 төг/
29	Ц.Цэрэнжав	Ардын язгуур урлаг - Морин хуур	Эрхийн бичиг /50,000 төг/
30	Х.Балхаш	Ардын язгуур урлаг - Домбор	Эрхийн бичиг /50,000 төг/
31	Л.Долгор	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи – Цагаан идээ	Батламж /100,000 төг/
32	Дижан	Уламжлалт гар урлал - Гар урлал	Эрхийн бичиг /50,000 төг/
33	Байзат Кунами	Уламжлалт гар урлал – гар урлал	Батламж /100,000 төг/
34	Дарханням	Ардын язгуур урлаг – Уртын дуу	Эрхийн бичиг /50,000 төг/
35	Д.Гантөгс	Эх хэл аман уламжлал-морь цоллох	Эрхийн бичиг /50,000 төг/
36	М.Давани	Ардын язгуур урлаг - Домбор	Эрхийн бичиг /50,000 төг/

37	О.Амарбат	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи - Цагаан идээ	Эрхийн бичиг /50,000 төг/
38	Ш.Амгалан	Уламжлалт гар урлал - Онъсон тоглоом, наадгай	Эрхийн бичиг /50,000 төг/
39	Г.Дархан-очир /хүүтэйгээ/	Ардын язгуур урлаг – Урианхай бий биелгээ	Эрхийн бичиг /50,000 төг/



Зураг.23-29 Нүүдэлчин Монгол наадмын 2 дугаар шатанд шалгарсан оролцогчдод эрхийн бичиг, батламж гардуулж байгаа нь





Зураг.30 Буриад ястан үндэстэнгүүд Дархан сумын Засаг даргын хамт





Зураг. 31-33 Оролцогчид

Төсөв, санхүү шийдвэрлэсэн байдал:

"Нүүдэлчин Монгол" наадмын I дүгээр шалгаруулалтыг аймгийн Соёл, урлагийн газрын санхүүгийн дотоод эх үүсвэрээр /1.098.500 төгрөг/ болон Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр /3,000,000 төгрөг/ зохион байгуулсан.

Мөн тус наадамд Шарын гол, Орхон, Хонгор сумдаас оролцсон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын ирэх, буцах тээврийн хэрэгслийн шатахууны зардлыг /240.000 төгрөг/ аймгийн Соёл, урлагийн газраас бүрэн хариуцсан.

Наадмын аносны эх бэлтгэл, хэвлүүлэх зардлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд "Сайн орших" ХХК хийж гүйцэтгэсэн.

БАТЛАВ.
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Б.ЖАВХЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН "НҮҮДЭЛЧИН МОНГОЛ" СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН
УЛАМЖЛАГЧДЫН НААДМЫН ТӨСӨВ

/ШАГНАЛ УРАМШУУЛАЛ/

№	Төрлийн нэр	Хүний тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Эх хэл аман уламжлал	4	75,000	300,000
2	Ардын язгуур	8	75,000	600,000
3	Уламжлалт гар урлал	7	75,000	525,000
4	Уламжлалт зан үйл, ёслол баяр наадам	7	75,000	525,000
5	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи	7	75,000	525,000
6	Мал маллах арга ухаан	2	75,000	150,000
7	Уламжлалт арга ухаан	5	75,000	375,000
	НИЙТ	40	75,000	3,000,000

Зураг.34 Аймгийн Засаг даргын орлогчоор батлуулсан төсөв

БАТЛАВ.

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

"НҮҮДЭЛЧИН МОНГОЛ" СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН-УЛАМЖЛАГЧДЫН НААДМЫН
ТӨСӨВ 4289366 1922050017 ГСТ7344

2022.07.05

Дархан Уул

№	Төрлийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Гэрийн бүрээс	ш	1	120,000	120,000
2	Айраг	литр	60	8,000	480,000
3	Ааруул	кг	3	25,000	75,000
4	Бяслаг	ш	1	15,000	15,000
5	Хэвийн боов	ш	15	8,500	127,500
6	Ундаа	ш	20	2,000	40,000
7	Ус 0.5	ш	20	1,900	38,000
8	Тавгийн чихэр	кг	3	25,000	75,000
9	Жигнэмэг	кг	3	7,500	22,500
10	Хуурай салфетка	боодол	2	2,500	5,000
11	Нойтон салфетка	боодол	2	6,500	13,000
12	1 удаагийн аяга	боодол	5	12,000	60,000
13	2 удаагийн халбага, сэрээ	боодол	2	8,000	16,000
14	Алчуур	ш	2	5,750	11,500
НИЙТ					1,098,500

Хянасан: Нягтлан бодогч

Төсөв боловсруулсан: Нярав

Т.Алтанцэцэг

Б.Долгормаа



2022.0708

Зураг. 35 Соёл, урлагийн газрын гэрийн төсөв

2022 оны 08 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо "Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар"-т болох "Нүүдэлчин Монгол" их наадамд оролцохоор Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 01-А/220 тоот Захирамжаар ажлын хэсгийг байгуулж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг Даргын орлогч, тус наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн дарга Б.Жавхлангаар батлуулан ажиллаж байна.

ТАЙЛАНГ БИЧСЭН:

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.СОЁЛ-ЭРДЭНЭ**